



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2009 оны 6 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

АРХИДАН СОГТУУРАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 9.2.7 дахь заалт нэмсүгэй:

“9.2.7.Зар сурталчилгааны тухай хуулийн 14¹ дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд 18 хувь хүртэл этилийн спирт агуулсан дарс, пиво, шимийн архины зар сурталчилгааг явуулах.”.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2009 оны 6 дугаар сарын 26-ны өдөр баталсан Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ